УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2021 оны 05 сарын 05 өдөр Дугаар А/96 Улаанбаатар хот

Нийслэлийн хүн амын махны хангамжийг бүрдүүлэх, үнийг тогтвортой хадгалах талаар авах зарим арга хэмжээний тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 72 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/889 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн хүн амын өвөл, хаврын улирлын махны хэрэгцээнд зориулан мал, мах бэлтгэн нийлүүлэх зарын дагуу санал ирүүлсэн аж ахуйн нэгжийн баримт бичгийг хүлээн авч нэгтгэн холбогдох байгууллагад уламжлах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, бэлтгэн нөөцөлсөн махыг худалдан борлуулах ажлыг жил бүр зохион байгуулах, хяналт тавих Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус байгуулсугай.
2. Нийслэлийн хүн амын махны хангамжийг бүрдүүлэх, үнийг тогтвортой хадгалах арга хэмжээнд мал, мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгжийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор баталсугай.
3. Мал, мах бэлтгэн нийлүүлэх санал ирүүлсэн аж ахуйн нэгжийн баримт бичгийг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн болон бэлтгэж нөөцөлсөн махыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажилласан талаар Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/889 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт тухай бүр тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгүүд /Т.Золжаргал/-д даалгасугай.
4. Бэлтгэсэн махны нөөц бүрдүүлэлт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын хэвийн үйл ажиллагааг хангуулах, хяналт шалгалтад шаардагдах тээврийн шатахуун зардлыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хот нийтийн аж ахуйн бусад зардлаас тухай бүр санхүүжүүлэхийг ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгзэдмаа/-т үүрэг болгосугай.
6. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/259 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

C:\Users\Gantuya\Desktop\УЖ 12\doc 2021\тушаал 2.docx

1110300315

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2024 оны 05 сарын 05 өдрийн
А/96 тушаалын 1 дүгээр хавсралт

МАЛ, МАХ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙН БАРИМТ БИЧИГ ХҮЛЭЭН АВАХ, ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД УЛАМЖЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл,худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /зөвшилцсөнөөр/

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн дарга

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн ерөнхий мэргэжилтэн

Нийслэлийн мал эмнэлгийн газрын дарга

Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэрэжилтэн

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн Тусгай хог хаягдал хариуцсан мэргэжилтэн

Монголын махны холбоо ТББ-ын Гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/

	Нийслэлийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн захирал /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Хүнсний хангамж, үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2024 оны 05 сарын 05 өдрийн
А/196 тушаалын 2 дугаар хавсралт

БЭЛТГЭН НӨӨЦӨЛСӨН МАХЫГ ХУДАЛДАН, БОРЛУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /зөвшилцсөнөөр/

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Нийслэлийн Мал эмнэлгийн газрын дарга

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн Систем төлөвлөлт, статистикийн албаны мэргэжилтэн

Нийслэлийн Татварын газрын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн дарга

Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Эргүүл хамгаалалтын тасгийн дарга

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн Дотоод хяналтын мэргэжилтэн

Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга

Монголын махны холбоо ТББ-ын менежер /зөвшилцсөнөөр/

Нийслэлийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн захирал /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамж хариуцсан ахлах мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 05 дүгээр сарын 05-ний өдрийн
А/196 дүгээр тушаалын Зургаа хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ӨВӨЛ, ХАВРЫН УЛИРЛЫН
МАХНЫ ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН МАЛ, МАХ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ
АЖ АХУЙН НЭГЖИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Аж ахуйн нэгжийн нэр: Огноо

№	Үзүүлэлт	Ирүүл-сэн	Ирүү-лээгүй
1	Аж ахуйн нэгжийн хүсэлт /бэлтгэх махны хэмжээг тусгах/		
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар		
3	Стандартын шаардлага хангасан агуулахтай мах боловсруулах үйлдвэр нь мал төхөөрөх үйлдвэртэй хамтран ажиллах гэрээ байгуулсан гэрээ		
4	Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр нь стандартын шаардлага хангасан агуулах бү=хий аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ		
5	Үйлдвэрийн танилцуулга		
6	Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналтын байгууллагаас гаргасан Улсын байцаагчийн дүгнэлт		
7	“Хүнсний түргэн муудах эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага. MNS 5343:2011 стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэлтэй байх; /Фото зураг хавсаргах/		
8	Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг ангилан ялгаж хадгалах зориулалтын талбай, байр, сав, бункертэй байх /Фото зураг хавсаргах/		
9	Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт дарж булшлах үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсан байх		
	Нийт		

--o0o--